



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 4/177

Улаанбаатар хот

“Шүд угаалтын аварга” шалгаруулах тэмцээн
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Улсын Их Хурлын 2020 оны “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын зорилт 2.2 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 322 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/353 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл шүд” арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор дүүргийн “Шүд угаалтын аварга” шалгаруулах тэмцээнийг 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр зохион байгуулсугай.

2. Тэмцээн зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар, зарцуулагдах хөрөнгийн төсвийг гуравдугаар тус тус баталсугай.

3. Арга хэмжээнд зарцуулагдах 2,500,000 (Хоёр сая таван зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Тэмцээний бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн төв (Х.Ганбат)-д, арга хэмжээний нээлт, хаалтын арга хэмжээ, хөгжим техник хэрэгслээр хангахыг Соёлын ордон (Б.Алтанцоож)-д, хүүхдүүдийн оролцоог хангахыг “Хангай” сургууль (Э.Соёмбобат)-д, ажлын хэсгийн гишүүдийг удирдлага, арга зүйгээр хангаж, тэмцээнийг чанар үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсэг (Б.Цогжавхлан)-т тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг дүүргийн Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL\2024 он ажил\захирамж

1123200397


Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 10 сарын 14 ны өдрийн 1117 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



“ШҮД УГААЛТЫН АВАРГА” ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Цогжавхлан	Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
Гишүүд:	Д.Оюунгэрэл	Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтсийн дарга
	Б.Алтанцоож	Соёлын ордны захирал
	Э.Соёмбобат	“Хангай” сургуулийн захирал
	Б.Нямгарав	Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн
	Б.Энхжаргал	Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
	Н.Цэцэглэн	Боловсролын хэлтсийн ахлах мэргэжилтэн
Нарийн бичиг:	Х.Ганбат	Эрүүл мэндийн төвийн дарга

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 10 сарын 04 ны өдрийн 41/7 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



“ШҮД УГААЛТЫН АВАРГА” ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

Үндэслэл: ДЭМБ-аас 2000 онд шүд цоорох өвчнийг олон шалтгаант халдварт өвчин хэмээн халдварт өвчний ангилалд оруулсан байдаг. Нийслэлийн хэмжээнд хийсэн судалгаанаас үзэхэд сургуулийн өмнөх болон сургуулийн бага, дунд ангийн хүүхдийн дунд шүд цоорох өвчний тархалт 2011 оны байдлаар 65-96 хувьтай байсан бөгөөд өнөөдөр ч энэ тоо буурахгүй хэвээр байна. Хүүхдүүдийн дунд шүд цоорох өвчний тархалт 86,2 хувьтай, шүд цоорох өвчний эрчим 6,2 цла/ш ДЭМБ-ын шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд өндөр түвшинд байна. Дүүргийн хэмжээнд ч энэ үзүүлэлт өндөр байна. Шүдний өвчлөл нь бүх өвчний үндэс суурь болж байгаа тул өвчлөлөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай.

2023 онд дүүргийн “Шүд угаалтын аварга” шалгаруулах тэмцээнийг анх удаа зохион байгуулсан бөгөөд хүүхдүүдийн дунд шүд угаах дадал хэвшил бий болсон эерэг үр нөлөө гарсан тул жил бүр уламжлал болгон зохион байгуулах хэрэгцээтэй байна.

Зорилго:

- 1.) “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- 2.) МУ-ын Засгийн газрын 2023 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл шүд” арга хэмжээг хэрэгжүүлэх
- 3.) ЭМЯ-наас дэвшүүлсэн “Зонхилон тохиолдох өвчнөөс сэргийлэх, иргэдэд эрүүл идэвхтэй амьдрах эрүүл зан үйлийг төлөвшүүлэх” зорилтыг хэрэгжүүлэх
- 4.) “Эрүүл шүд” арга хэмжээний Нийслэл, дүүргийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах
- 5.) ЕБС-ийн хүүхдүүдийн амны хөндийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, шүд угаах зөв аргачлалыг эзэмшүүлэх, шүд угаахын ач холбогдлыг олон нийтэд танилцуулах, сурталчлах

Нэг: Зохион байгуулалт, хамрах хүрээ

Зохион байгуулагч:

- ✚ Эрүүл мэндийн төв
- ✚ Нийслэлийн Шүд, эрүү нүүрний төв
- ✚ “Хангай” сургууль

1.1.) Тэмцээн 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр Соёлын ордонд зохион байгуулагдана.

1.2.) Тэмцээнд “Хангай” сургуулийн 9-12 насны буюу 4-7-р ангийн сурагчид хамрагдана. 4,5-р анги, 6,7-р анги гэсэн ангиллаар өрсөлдөнө.

1.3.) Анги тус бүрээс шүд угаах зөв дадалд суралцсан болон шүдний өвчлөлгүй 6 хүүхэд 1 баг болж оролцоно.

1.4.)Тэмцээнд оролцох ангийн эцэг эх, асран хамгаалагч болон, сурагчид “Шүд угаах” зөв дадлын талаар сургалтад хамрагдсан байна.

1.5.)Тэмцээн сүлд дуутай, лого тэмдэгтэй байна.

1.6.)Ангиудын хувцаслалт жигд, багийн нэртэй байна.

1.7.)Тэмцээн өртөөчилсөн байдлаар зохион байгуулагдана. 5 өртөөтэй байна.

1-р өртөө: Хүлээх хэсэг

2-р өртөө: Шүд угаалтын онолын тест бөглөх, жигнэмэг идүүлэх хэсэг

3-р өртөө: Шүд угаалт, шүдний утас хэрэглэх, шүд угаалтыг хянах, оноо өгөх хэсэг

4-р өртөө: Шүдний өнгөр шалгаж будах хэсэг

5-р өртөө: Шүдний гадаргуу дээрх өнгөр үнэлэх хэсэг

1.8.)Шүд угаах тэмцээнийг доорх зураглалаар явуулна

5	4	3	2	1		Сандал
						Ширээ
						Энгийн хогийн сав
						Эмнэлгийн хогийн сав
						Үзлэгийн ор

1.9.)Өртөө бүр 6 хэсэгтэй. 1-р өртөөнд 12 багш сурагчдаа зохион байгуулна.

1.10.)2, 3, 4,5 -р өртөөн дээр 4 шүүгч, 20 хяналтын ажилтан ажиллана

1.11.)2-р өртөөний шүүгч ЗДТГ, ЭМТ, ХГБХХХ-ийн мэргэжилтнүүд байна.

Бусад өртөөний шүүгч эмч, эмнэлгийн ажилтан байна

1.12)1-р өртөө: Хүлээх хэсэг. Багш багуудыг хувцсаар жигдрүүлж, багийг бэлтгэнэ, эмх цэгцтэй бусдад саад учруулахгүй байлгах үүргийг хүлээнэ.

1.13)2-р өртөө: Сурагчид шүд угаалтын талаарх 5 асуулт бүхий онолын тест бөглөж, шүдийг санаатайгаар бохирдуулах зорилгоор жигнэмэг иднэ

1.14)3-р өртөө: Шүдээ Бассын аргаар оогүйгээр угааж, шүдний завсрыг шүдний утсаар цэвэрлэн шүд угаалтыг үнэлүүлнэ

1.15)4-р өртөө: Шүдний гадаргуун дээрх өнгөрийг тодорхойлохдоо будагч бодис бүхий шахмалыг шүдний бүх хэсгээр сайтар зажлуулна, зажлах явцдаа залгихыг хатуу хориглоно

1.16)5-р өртөө: Шүдний гадаргуу дээрх өнгөрийг эмч нэг удаагийн багаж хэрэгсэл ашиглан үзлэг хийж тусгай үнэлгээний хуудсаар үнэлж оноог нэгтгэнэ

1.17)Нэг өртөөн дээр 4 минут, нийт нэг баг 20 минут зарцуулах ба энэ хугацаанд тэмцээний сүлд дуу 2 удаа явна

Хоёр: Тэмцээний дүн гаргах, шалгаруулалт

2.1)Тэмцээнд оролцсон нийт багаас 5 өртөөний нийлбэр оноо болон зохион байгуулалтын дүнгээр тэргүүлсэн ангилал тус бүрээс 2 багийг шалгаруулж байр эзлүүлнэ.

Жич: Зохион байгуулалтын дүнд дараах арга хэмжээг тооцно

- ❖ Эцэг эх асран хамгаалагч болон сурагчдын сургалтад хамрагдсан ирц
- ❖ Хувцаслалт
- ❖ Бүтээлч ажил ханын сонин
- ❖ Зохион байгуулалт, дэг журам

Шагнал:

4,5-р анги: Тэргүүн байр -Цом, өргөмжлөл, 200,000 төгрөг

4,5-р анги: Дэд байр - Өргөмжлөл, 100,000 төгрөг

6,7-р анги: Тэргүүн байр- Цом, өргөмжлөл, 200,000 төгрөг

6,7-р анги: Дэд байр- Өргөмжлөл, 100,000 төгрөг

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 10 сарын 24 ны өдрийн 4.1.17 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

“ШҮД УГААЛТЫН АВАРГА” ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД
ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ

№	Материалын нэрс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ (төг)	Нийт үнэ (төг)
1.	Сойз	ш	78	5,500	429,000
2.	Шүдний утас (50-100м)	ш	6	5,000	30,000
3.	Ус	ш	78	1,600	124,800
4.	Нэг удаагийн аяга	ш	200	130	26,000
5.	Салфетик (нойтон)	ш	78	1,500	117,000
6.	Салфетик (хуурай)	ш	6	5,000	30,000
7.	Үзлэгийн нэг удаагийн толь	ш	78	5,000	390,000
8.	Гарын шингэн саван	ш	2	7,000	14,000
9.	Печень	ш	78	2,000	156,000
10.	Бичгийн цаас	боодол	1	16,600	16,600
11.	Бал	ш	36	1,000	36,000
12.	Чихний хөвөнтэй мод	ш	6	5,000	30,000
13.	Өнгөр шалгагч	ш	78	1,200	93,600
14.	Өргөмжлөл	ш	4	25,000	100,000
15.	4,5, 6,7 дугаар ангийн тэргүүн байрны шагнал	ш	2	200,000	400,000
16.	4,5, 6,7 дугаар ангийн дэд байрны шагнал	ш	2	100,000	200,000
17.	Шилдэг ангийн цом	ш	2	25,000	50,000
18.	Шүүгч, эмч нарын хоол	ш	20	12,850	257,000
	НИЙТ				2,500,000